

**ЗҮҮН ӨМНӨД АЗИЙН ТӨВ БАНКУУДЫН СУРГАЛТ, СУДАЛГААНЫ ТӨВИЙН
ЗАХИРЛУУДЫН ЗӨВЛӨЛИЙН 32 ДАХЬ УДААГИЙН УУЛЗАЛТ, ЗӨАТБХ-НЫ
ЕРӨНХИЙЛӨГЧ НАРЫН 48 ДАХЬ УДААГИЙН ЧУУЛГА УУЛЗАЛТ БОЛОН ДЭЭД
ХЭМЖЭЭНИЙ ЗӨВЛӨГӨӨН**

(2012 оны 11 дүгээр сарын 22 – 24)

Улаанбаатар, Монгол Улс

ХЭВЛЭЛИЙН НЭГДСЭН МЭДЭГДЭЛ

Зүүн-Өмнөд Азийн Төв Банк (ЗӨАТБ)-уудын Сургалт, судалгааны төвийн Захирлуудын зөвлөлийн 32 дахь удаагийн уулзалт, Ерөнхийлөгч нарын 48 дахь удаагийн чуулга уулзалт болон дээд хэмжээний зөвлөгөөн Монгол улсын нийслэл Улаанбаатар хотноо 2012 оны 11-р сарын 22-ноос 24-ний хооронд зохион байгуулагдлаа. Энэхүү арга хэмжээнд ЗӨАТБ-уудын Сургалт, судалгааны төвийн гишүүн Төв банкууд, мөнгөний эрх баригчид¹, мөн стратегийн түнш байгууллагуудын төлөөлөгчид оролцлоо. Чуулга уулзалтын сэдэв нь “Олон улсын санхүүгийн зах зээлийн харилцан хамаарал ба мөнгөн хөрөнгийн урсгалын өндөр хэлбэлзэл” байв.

Монгол Улсын Ерөнхий сайд Норовын Алтанхуяг уулзалтыг нээж хэлсэн үгэндээ олон улсын санхүүгийн зах зээл улам нэгдмэл болсноор хөгжиж буй орнууд олон улсын санхүүгийн захаас өөрт нэн шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг босгох боломжтой болсныг онцолсон байна. Гэхдээ Азийн олон орны эдийн засгийн бүтэц, институцийн чадавхи, макро бодлогын орчин нь хөрөнгийн том урсгалыг эрсдэлгүй ашиглах түвшинд хүрээгүй байгааг тэрээр дурьджээ. Ийм учраас улс орнууд хөрөнгийн дотогшлох урсгалын эрсдэл хуримтлагдахаас сэргийлэх сорилт тулгарч байгааг тэрээр мөн онцолжээ.

Монголбанкны Ерөнхийлөгч Н.Золжаргал уулзалтыг нээж хэлсэн үгэндээ бүс нутгийн санхүүгийн зах зээлийн хөгжил болон тогтвортой байдлыг сурталчлахад ЗӨАТБ-уудын Сургалт, судалгааны төвийн оруулж байгаа хувь нэмрийг нь сайшаасан байна. Тэрээр Төв банкууд болон мөнгөний эрх баригчдын хамтын ажиллагааг бэхжүүлэх, харилцан туршлага солилцох боломжийг хөхүүлэн дэмжлээ. Солонгосын Төв банкны Ерөнхийлөгч ноён ЧүнгСү Ким хариу хандаж хэлсэн үгэндээ олон улсын санхүүгийн харилцан хамаарал нь эдийн засгийн өсөлт, тогтвортой байдал болон дархлааг сайжруулан үр өгөөжөө өгдгийг онцолсон байна. Мөн тэрээр мэдээлэл солилцоо болон бодлогын уялдаа холбоо хэзээ хэзээнээс чухал болсныг цохон тэмдэглэсэн.

Чуулга уулзалтад Монголбанкны эдийн засагч Г.Борхүү, ОУВС-гийн Ази-Номхон Далайн бүс нутгийн төлөөллийн тэргүүн ноён Жерард Ж.Алмекиндерс, Олон улсын төлбөр тооцооны банкны ерөнхий захирал ноён Жайме Каруана болон тус банкны Ази-Номхон далайн бүс нутгийг хариуцсан ахлах төлөөлөгч ноён Эли Ремолона нар илтгэл тавилаа. Захирлуудын Зөвлөлийн уулзалтыг Монголбанкны Ерөнхийлөгч Н.Золжаргал, Төв банкуудын Ерөнхийлөгч нарын хурлыг Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч Б.Жавхлан нар удирдан явуулсан. Дээд хэмжээний зөвлөгөөнийг Шри-Ланкийн Төв

¹ ЗӨАТБ-уудын Сургалт, судалгааны төв одоогоор Бруней Дарусаламын Мөнгөний эрх баригч; Камбожын Үндэсний банк; Хятадын Төв банк; Фижигийн Нөөцийн банк; Индонезийн банк; Солонгосын банк; Лаосын Төв банк; Малайзийн Негара банк; Монголбанк; Мьянмарын Төв банк; Непалын Растра банк; Папуа Шинэ Гвинейгийн банк; Филиппины Төв банк; Сингапурын Мөнгөний эрх баригч; Шри Ланкын Төв банк; Хятадын Тайваны Төв банк; Тайландын банк болон Вьетнамын Улсын банк хэмээх 18 гишүүдээс бүрддэг.

банкны Ерөнхийлөгч ноён Ажит Нивард Кабраал болон Тайландын Төв банкны Ерөнхийлөгч Доктор Празарн Трайратворакул нар хамтран удирдлаа.

Төв банкуудын Ерөнхийлөгч нарын үзэж буйгаар Ази дэлхийн бусад улс орнуудтай худалдаа, санхүүгийн салбараар дамжин нягт холбогдсоныг тэмдэглэсэн байна. Хөгжингүй орнуудын эдийн засгийн хүндрэл бэрхшээл гадаад эрэлтийг сулруулан эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж байгаа ч Азийн эдийн засгийн сөрөх чадвар өндөр байна. Иймд өсөлтийг хэвээр нь хадгалах, эрсдэлийг багасгах бодлого хэрэгжүүлэх орон зай хангалттай байгаа юм. Гэхдээ ерөнхийлөгч нар тогтвортой өсөлтийг хангахын тулд Ази тив эрэлтээ дотоод хэрэглээ, хөрөнгө оруулалт руу чиглүүлэх, бүс нутгийн худалдаагаа өргөжүүлэх хэрэгтэйг хүлээн зөвшөөрсөн байна.

Дэлхийн улс орнуудын эдийн засгийн харилцан хамаарлаас үүдэн хямрал нь Азийн эдийн засагт худалдаа болон санхүүгийн сувгийн аль алинаар дамжсаныг хүлээн зөвшөөрлөө. Ийм нөхцөлд Төв банкуудын үүрэг нэмэгдэн санхүүгийн тогтвортой байдлыг мөн хамрах болов. Тиймээс Төв банкууд тогтвортой өсөлтийг хангахын тулд макро зохистой бодлого арга хэмжээг мөнгөний бодлого боловсруулахдаа харгалзан үзэх нь зайлшгүй талаар мөн ялангуяа хямралын үед бодлогыг цаг алдалгүй хэрэгжүүлэх ач холбогдолтойг чухалчилсан.

Ерөнхийлөгч нар тодорхой бүс нутагт тохирсон нөөцийн арга хэмжээ авах хэрэгтэйг дахин дурдсанаас гадна бүс нутгийн санхүүгийн нэгдмэл байдлыг бодит секторын хэмжээнд авч үзэх хэрэгтэйг онцолсон. Ерөнхийдөө, Ерөнхийлөгч нар дэлхий нийтийн олон талт санхүүгийн системийг нэвтрүүлэх, санхүүгийн хямралын давтамж, нөлөөг бууруулахын тулд санхүүгийн системийг шинэчлэх шаардлагатай байна гэж үзсэн.

Хөгжингүй орнуудад хэрэгжүүлсэн хүүний бус хэмжээний зөөлрүүлэх бодлогын үр дүнг авч үзсэнээр, бодлогын стратеги нь эрчимтэй хөгжиж буй дотоодын эдийн засаг, дэлхийн эдийн засагтай нийцтэй байх ёстой бөгөөд тус бодлогыг олон талын хамтын ажиллагаанд тохирсон, уялдаа холбоо сайтай боловсруулах ёстойг тэмдэглэсэн. Ерөнхийлөгч нар Ази тив нь өөрийн дотоод болон дэлхийн асуудлуудыг ойлгож, суралцаж, илүү хүчтэй бүс нутгийн санхүүгийн системийг нэвтрүүлэх замаар учирч болох хүндрэлийг даван туулах болно хэмээн тодорхойлсон. Ерөнхийлөгч нар ЗӨАТБ-уудын Сургалт, судалгааны төв, Төв банкуудын чадавхийг бий болгох, хамтын ажиллагааг хөхүүлэн дэмждэг байгууллагын хувьд бүс нутгийн үзэл баримтлалыг бий болгоход зохих хувь нэмрийг оруулж чадахыг онцолжээ.

ЗӨАТБ-уудын Сургалт, судалгааны төвийн Захирлуудын зөвлөлийн 32 дахь удаагийн уулзалтаар Энэтхэгийн Нөөцийн банкыг 2013 оны 1-р сарын 1-нээс 19 дэх гишүүн улсаар хүлээн зөвшөөрөхөөр шийдвэрлэжээ.

Ерөнхийлөгч нар Непалын Растра банкнаас санал болгосон ЗӨАТБ-уудын Сургалт, судалгааны төвийн Захирлуудын зөвлөлийн 33 дахь удаагийн уулзалт, ЗӨАТБ-уудын Сургалт, судалгааны төвийн ерөнхийлөгч нарын 49 дахь удаагийн чуулга уулзалтыг 2013 онд зохион байгуулах хүсэлтийг талархан хүлээн авлаа.

Түүнчлэн энэ удаагийн чуулга уулзалт болон дээд хэмжээний зөвлөгөөнийг өндөр түвшинд зохион байгуулж, халуун дотно хүлээж авсан Монголбанкны хамт олонд талархсанаа илэрхийлжээ.